

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ӨМА-2023/28-15-ШТА-ГА

ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Даланзадгад хот 2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Аудитор Э.Бат-Эрдэнэ

Утас: 70533552 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлал.....	2
Хүснэгтийн жагсаалт.....	2
Графикийн жагсаалт.....	2
Дүрслэлийн жагсаалт.....	2
Зургийн жагсаалт.....	2
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	3
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	4
БҮЛЭГ 1. ӨМНӨГОВЬ АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХИЙХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ЖИЛ БҮР БУУРСААР БАЙНА	7
А.1 Улсын төсвийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн үндсэн зорилготой нийцэхгүй байна	7
А.2 Орон нутгийн хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийн дагуу эрэмбэлсэн төсөл, арга хэмжээ улсын төсөвт бүрэн тусгагдаагүй байна	9
БҮЛЭГ 2. ЗАХИАЛАГЧ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	11
Б.1 Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан байна.....	11
Б.2 Гүйцэтгэгчтэй байгуулсан зарим гэрээний хугацаа дууссан байна.....	12
Б.3 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн, хугацаанд нь олгосон байна.....	15
Б.4 Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.....	16
Б.5 Төсөл, арга хэмжээний бүртгэл хөтлөлтийг хууль журмын дагуу сайжруулах шаардлагатай байна.....	16
БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТНЫ АЖЛЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	16
В.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд аудитын дүгнэлтийг тусгах шаардлагатай байна.....	16
В.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд илэрсэн зөрчлүүд үр дүнг бууруулж байна.....	19
ДҮГНЭЛТ.....	26
ЗӨВЛӨМЖ.....	27
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ.....	28

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
ХШУДАХ	Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Харьцуулалтын арга
ЗҮГСЖ	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ШТА	Шууд тайлагнах аудит
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ТАХ	Төсөл арга хэмжээ
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар

ХҮСНЭГТ, ДҮРСЛЭЛ, ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	Батлагдсан төсөл, арга хэмжээ	4
Хүснэгт 2	Хөрөнгө оруулалтыг Алсын хараа 2050-ын зорилтоор ангилсан байдал	7
Хүснэгт 3	Шинээр хийгдэхээр батлагдсан барилга байгууламжийн судалгаа	8
Хүснэгт 4	2022 он эрх шилжиж ирсэн шинээр хийх төсөл, арга хэмжээ	10
Хүснэгт 5	2022 онд хийсэн ХАА зарласан төсөл, арга хэмжээ	11
Хүснэгт 6	2022 оны батлагдсан төсөв, ОНТХО-ын төлөвлөгөө	17
Хүснэгт 7	Төсөл, арга хэмжээний ангилал	18
Хүснэгт 8	Төсөл, арга хэмжээний ангилал	19
Хүснэгт 9	Үнэлгээний хороон ажилласан иргэдийн судалгаа	20
График 1	Улсын төсвөөр хийсэн хөрөнгө оруулалтын дүрслэл	9
Зураг 1	Цогт-Овоо сумын “Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга”	13
Зураг 2	Дуут манханд хийсэн отоглох цэг	13
Зураг 3	Ёлын аманд хийсэн отоглох цэг	13
Зураг 4	Гурвантэс сумын Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга	14
Зураг 5	Хүрмэн сумын Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга	14
Зураг 6	Цогт-Овоо сумын сургуулийн барилга /одоогийн/	14
Зураг 7	Нийлүүлсэн автомашин	15
Зураг 8	Цогтцэций сумын сургуулийн барилга	15
Зураг 9	Өрөөний зохион байгуулалт	21
Зураг 10	Усалгааны автомашин	21
Зураг 11	Сургуулийн цайны газар	22
Зураг 12	Ашиглахгүй байгаа хөрөнгө	22
Зураг 13	Ашиглахгүй байгаа хөрөнгө	22
Зураг 14	Хүрмэн сумын сургууль	23
Зураг 15	Уурын зуухны барилга	23
Зураг 16	Хөгжимт жүжгийн театр	24
Зураг 17	Өрхийн эмнэлэг	25

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/04 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-нд тусгасан дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилго, хамарсан хүрээ

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэсэн. Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх?
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх?
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх?

Аудитад Өмнөговь аймагт 2022 онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол улсын аудитын стандарт MNS 6817-5:2020, гүйцэтгэлийн аудитын зарчим MNS 6817-6:2020, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад асуудлын шинжилгээний дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, гүйцэтгэлийн аудитын арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байх зарчим болон дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- “Алсын хараа” 2050 Монгол Улсын урт хугацааны урт хугацааны хөгжлийн бодлого,
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”

- Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр хянан удирдаж, аудитын менежер Т.Хонгорзул үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор Э.Бат-Эрдэнэ нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуульд Өмнөговь аймагт он дамжин хэрэгжих 11, шинээр хэрэгжих 14 нийт 41,599.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 25 төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд 6,241.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 1 Баталсан төсөл, арга хэмжээ

/сая.төгрөг/

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Шинэ, шилжих	Эрх шилжсэн эсэх /тийм, үгүй/	Хугацаа		Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
						Эхлэх	Дуусах		
1	IV.1.1.1	Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	Барилга байгууламж	Шилжих	тийм	2018	2022	3,153.5	100.0
2	XII.1.1 17	Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга /Өмнөговь, Хүрмэн сум/	Барилга байгууламж	Шинэ	тийм	2022	2022	150.0	150.0
3	XII.1.1 17	Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга /Өмнөговь, Цогт-Овоо сум/	Барилга байгууламж	Шинэ	тийм	2022	2022	150.0	150.0
4	XII.1.1 17	Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга /Өмнөговь, Гурвантэс сум/	Барилга байгууламж	Шинэ	тийм	2022	2022	150.0	150.0
5	XII.1.1 43	Үер, ус зайлуулах төв магистраль шугам сүлжээ, 5 км /Өмнөговь, Даланзадгад сум/	Барилга байгууламж	Шинэ	үгүй	2022	2023	3,829.6	200.0
6	XII.1.5 8	Төрийн албан хаагчдын орон сууцны барилга, 14 айл /Өмнөговь, Баян-Овоо сум/	Барилга байгууламж	Шилжих	тийм	2021	2022	1,055.6	526.6
7	XII.3.7	Хог хаягдал боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж /Өмнөговь, Даланзадгад сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	үгүй	2022	2022	200.0	200.0
8	XIII.1.1.121	Сургуулийн спорт заалны барилга /Өмнөговь, Булган сум/	Барилга байгууламж	Шилжих	тийм	2019	2022	1,598.5	10.5
9	XIII.1.1.147	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 200 ор /Өмнөговь, Цогтцэций сум/	Барилга байгууламж	Шилжих	тийм	2020	2022	1,155.0	700.0
10	XIII.1.1.259	Дотуур байрны барилга, 120 ор /Өмнөговь, Даланзадгад сум/	Барилга байгууламж	Шинэ	үгүй	2022	2023	2,274.2	349.5

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

11	XIII.1.1.51	Сургуулийн барилга, 320 суудал /Өмнөговь, Номгон сум/	Барилга байгууламж	Шилжих	тийм	2018	2022	4,748.0	234.0
12	XIII.1.3.31	Сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж /Өмнөговь/	Тоног төхөөрөмж	Шилжих	үгүй	2022	2022	450.0	90.0
13	XIII.1.1.52	Сургуулийн барилга, 320 суудал /Өмнөговь, Цогт-Овоо сум/	Барилга байгууламж	Шилжих	тийм	2019	2022	3,500.0	194.1
14	XIV.1.54	Аймгийн номын сангийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	Барилга байгууламж	Шинэ	үгүй	2022	2024	4,200.0	105.4
15	XIV.3.10	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Өмнөговь, Мандал-Овоо сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	үгүй	2022	2022	40.0	40.0
16	XIV.1.23	Соёлын төвийн барилга /Өмнөговь, Ноён сум/	Барилга байгууламж	Шилжих	тийм	2012	2022	895.0	105.4
17	XIX.1.29	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өмнөговь, Сэврэй сум/	Барилга байгууламж	Шилжих	үгүй	2021	2023	3,152.4	600.0
18	XIX.1.59	Сэргэн засах эмнэлгийн барилга, 40 ор /Өмнөговь, Даланзадгад сум, 6 дугаар баг/	Барилга байгууламж	Шинэ	үгүй	2022	2023	4,692.0	140.0
19	XIX.3.8	Алслагдсан сумдын дуудлагын түргэн тусламжийн зориулалтаар тоноглогдсон автомашин /Өмнөговь, Даланзадгад, Гурвантэс, Ханбогд, Ноён, Цогтцэций сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	тийм	2022	2022	1,000.0	1,000.0
20	XIX.1.28	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өмнөговь, Манлай сум/	Барилга байгууламж	Шилжих	үгүй	2020	2022	1,445.4	77.9
21	XVII.3.3	Хөдөө аж ахуйн дундын техник үйлчилгээний төвийн явуулын барилга, тоног төхөөрөмж /Өмнөговь, Булган сум/	Тоног төхөөрөмж	Шилжих	үгүй	2020	2022	1,900.0	650.0
22	XVII.3.12	Малчид болон орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн тоног төхөөрөмж /Өмнөговь, Баяндалай, Мандал-Овоо, Ханхонгор, Ханбогд, Номгон, Манлай, Баян-Овоо, Сэврэй, Ноён, Цогтцэций, Булган сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	үгүй	2022	2023	1,650.0	258.3
23	X.4.3.3	Хилийн 0131 дугаар ангийн Цагаан-Уулын заставын тоног төхөөрөмж /Өмнөговь, Хүрмэн сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	үгүй	2022	2022	10.0	10.0
24	VI.1.1.6	Өмнөговь аймгийн аялал жуулчлалын бүс, байгаль, түүх соёлын өв бүхий Хонгорын голын Дуут манханд отоглох цэг байгуулах	Барилга байгууламж	Шинэ	тийм	2022	2022	100.0	100.0
25	VI.1.1.6	Өмнөговь аймгийн аялал жуулчлалын бүс, байгаль, түүх соёлын өв бүхий газар /Ёлын амын Оюут/-т отоглох цэг байгуулах	Барилга байгууламж	Шинэ	тийм	2022	2022	100.0	100.0
Нийт								41,599.2	6,241.7

Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл хөтөлбөрт олгох санхүүжилтийн 64 хувийг барилга, байгууламж, 36 хувийг тоног төхөөрөмжид зарцуулахаар төлөвлөсөн байна.

Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолуудаар 2022 онд нийт 619,464.2 сая төгрөгийн орлого, 619,464.2 сая төгрөгийн зардал, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 439 төсөл, арга хэмжээнд 122,352.9 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тус тус баталжээ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт нийт зардлын 19,7 хувийг эзэлж байна.

Жил бүр улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитаар Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д заасантай нийцэхгүй орон нутгийн өмчлөлд хамаарахгүй, улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авдаг зөрчил давтагдсаар байна.

БҮЛЭГ 1. ӨМНӨГОВЬ АЙМАГТ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХИЙХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ЖИЛ БҮР БУУРСААР БАЙНА.

А.1 Улсын төсвийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн үндсэн зорилготой нийцэхгүй байна.

1.1 Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан байна. Хөгжлийн бодлого нь чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлэхэд чиглэгддэг байна.

1.2 Монгол Улсын 2022 оны төсвийн хөрөнгөөр Өмнөговь аймагт хийхээр төлөвлөсөн 25 төсөл арга хэмжээг “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилтоор нь ангилбал дараах байдалтай байна.

Хүснэгт 2 Хөрөнгө оруулалтыг Алсын хараа 2050-ын зорилтоор ангилсан байдал

№	Зорилт	ТАХ-ны тоо	Эзлэх хувь
1	Хүний хөгжил	14	56
2	Амьдралын чанар ба дундаж давхарга	4	16
3	Амар тайван аюулгүй нийгэм	1	4
4	Эдийн засаг	0	0
5	Ногоон хөгжил	3	12
6	Бүсчилсэн хөгжил	0	0
7	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	3	12
8	Сайн засаглал	0	0
Нийт		25	100

Эх сурвалж: Аудиторын судалгаа

1.3 Хүснэгтээс харахад “Хүний хөгжил”-ийн зорилтод боловсрол, эрүүл мэнд, хүнд ээлтэй орчинд чиглэсэн төсөл, арга хэмжээг түлхүү төлөвлөсөн бол “Эдийн засаг”, “Бүсчилсэн хөгжил”, “Сайн засаглал” -т чиглэсэн төсөл, арга хэмжээг 2022 онд төлөвлөөгүй байна.

1.4 Энэ нь орон нутагт амьдарч байгаа иргэдийн орчин нөхцөлийг сайжруулах урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилт бүрийг хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөх шаардлагатайг харуулж байна.

1.5 Улсын төсвийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээнүүд “Алсын хараа 2050” -ийн зорилттой уялдсан ч зорилтын үндсэн шаардлагатай зарим талаараа нийцэхгүй байна.

1.6 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн онд хэрэгжүүлэхээр шинээр төлөвлөсөн 9 барилга, байгууламж, 5 тоног төхөөрөмж байна.

Хүснэгт 3 Шинээр хэрэгжүүлэхээр баталсан барилга байгууламжийн судалгаа /сая.төг/

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Шинэ, шилж их	Эрх шилжсэн эсэх /тийм, үгүй/	Хугацаа		Төсөвт өртөг	2022 онд санхүүж их дүн
						Эхлэх	Дуусах		

1	XII.1.117	Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга /Өмнөговь, Гурвантэс сум/	Барилга байгууламж	Шинэ	тийм	2022	2022	150.0	150.0
2	XII.1.117	Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга /Өмнөговь, Хүрмэн, сум/	Барилга байгууламж	Шинэ	тийм	2022	2022	150.0	150.0
3	XII.1.117	Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга /Өмнөговь, Цогт-Овоо, сум/	Барилга байгууламж	Шинэ	тийм	2022	2022	150.0	150.0
4	XII.1.143	Үер, ус зайлуулах төв магистраль шугам сүлжээ, 5 км /Өмнөговь, Даланзадгад сум/	Барилга байгууламж	Шинэ	үгүй	2022	2023	3,829.6	200.0
5	XII.3.7	Хог хаягдал боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмж /Өмнөговь, Даланзадгад сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	үгүй	2022	2022	200.0	200.0
6	XIII.1.1.2 59	Дотуур байрны барилга, 120 ор /Өмнөговь, Даланзадгад сум/	Барилга байгууламж	Шинэ	үгүй	2022	2023	2,274.2	349.5
7	XIV.1.54	Аймгийн номын сангийн барилга /Өмнөговь, Даланзадгад сум/	Барилга байгууламж	Шинэ	үгүй	2022	2024	4,200.0	105.4
8	XIV.3.10	Соёлын төвийн тоног төхөөрөмж /Өмнөговь, Мандал-Овоо сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	үгүй	2022	2022	40.0	40.0
9	XIX.1.59	Сэргээн засах эмнэлгийн барилга, 40 ор /Өмнөговь, Даланзадгад сум, 6 дугаар баг/	Барилга байгууламж	Шинэ	үгүй	2022	2023	4,692.0	140.0
10	XIX.3.8	Алслагдсан сумдын дуудлагын түргэн тусламжийн зориулалтаар тоноглогдсон автомашин /Өмнөговь, Даланзадгад, Гурвантэс, Ханбогд, Ноён, Цогтцэций сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	тийм	2022	2022	1,000.0	1,000.0
11	XVII.3.12	Малчид болон орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн тоног төхөөрөмж /Өмнөговь, Баяндалай, Мандал-Овоо, Ханхонгор, Ханбогд, Номгон, Манлай, Баян-Овоо, Сэврэй, Ноён, Цогтцэций, Булган сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	үгүй	2022	2023	1,650.0	258.3
12	X.4.3.3	Хилийн 0131 дугаар ангийн Цагаан-Уулын заставын тоног төхөөрөмж /Өмнөговь, Хүрмэн сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	үгүй	2022	2022	10.0	10.0
13	VI.1.16	Өмнөговь аймгийн аялал жуулчлалын бүс, байгаль, түүх соёлын өв бүхий Хонгорын голын Дуут манханд отоглох цэг байгуулах	Барилга байгууламж	Шинэ	тийм	2022	2022	100.0	100.0
14	VI.1.16	Өмнөговь аймгийн аялал жуулчлалын бүс, байгаль, түүх соёлын өв бүхий газар /Ёлын амын Оюут/-т отоглох цэг байгуулах	Барилга байгууламж	Шинэ	тийм	2022	2022	100.0	100.0

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

1.7 Дээрх төсөл арга хэмжээнүүд “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгагдаагүй байна.


1.8 Өмнөговь аймагт “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т туссан хийхээр төлөвлөсөн томоохон гол ажлууд одоог хүртэл хэрэгжиж эхлээгүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх төсөл, арга хэмжээнд тусгагдахгүй байна. Тухайлбал:

- Таван толгойн нүүрсний бүлэг ордод технологийн шинэчлэл хийж, олборлолтыг төслийн хүчин чадалд хүргэх, нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах төсөл,
- Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн 220 кВ-ын хоёр хэлхээт цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц,
- Таван толгойн 450 МВт-ын цахилгаан станц,

1.9 Өмнөговь аймгийн улсын төсөвт төвлөрүүлэх орлого жил бүр нэмэгдсээр байхад улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээ жил ирэх бүр буурсаар байна. Энэ нь хэнийг ч орхигдуулахгүй байх зарчимтай нийцэхгүй байна.

/График-1/ Улсын төсвөөр хийсэн хөрөнгө оруулалтын дүрслэл

/сая төгрөг/



A.2 Орон нутгийн хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийн дагуу эрэмбэлсэн төсөл, арга хэмжээ улсын төсөвт бүрэн тусгагдаагүй байна.

2.1 Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д "Хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг", 68 дугаар зүйлийн 68.2-д "Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана." гэсэн хуулийн заалттай.

2.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжихээр эрх шилжсэн 6 төсөл, арга хэмжээнээс барилга байгууламж - 5, тоног төхөөрөмж -1 байна.

Хүснэгт 4 2022 он эрх шилжиж ирсэн шинээр хийх төсөл, арга хэмжээ

/сая.төг/

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөл, арга хэмжээний ангилал	Шинэ, шилжих	Эрх шилжсэн эсэх /тийм, үгүй/	Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн
1	XII.1.117	Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга /Өмнөговь, Хүрмэн, Цогт-Овоо, Гурвантэс сум/	Барилга байгууламж	Шинэ	тийм	150.0	150.0
2	XII.1.117	Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга /Өмнөговь, Хүрмэн, Цогт-Овоо, Гурвантэс сум/	Барилга байгууламж	Шинэ	тийм	150.0	150.0

3	XII.1.117	Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга /Өмнөговь, Хүрмэн, Цогт-Овоо, Гурвантэс сум/	Барилга байгууламж	Шинэ	тийм	150.0	150.0
4	XIX.3.8	Алслагдсан сумдын дуудлагын түргэн тусламжийн зориулалтаар тоноглогдсон автомашин /Өмнөговь, Даланзадгад, Гурвантэс, Ханбогд, Ноён, Цогтцэций сум/	Тоног төхөөрөмж	Шинэ	тийм	1,000.0	1,000.0
5	VI.1.16	Өмнөговь аймгийн аялал жуулчлалын бүс, байгаль, түүх соёлын өв бүхий Хонгорын голын Дуут манханд отоглох цэг байгуулах	Барилга байгууламж	Шинэ	тийм	100.0	100.0
6	VI.1.16	Өмнөговь аймгийн аялал жуулчлалын бүс, байгаль, түүх соёлын өв бүхий газар /Ёлын амын Оюут/-т отоглох цэг байгуулах	Барилга байгууламж	Шинэ	тийм	100.0	100.0

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

2.3 Хүснэгтээс харахад 2022 онд орон нутагт хөрөнгө оруулалтын бус шинж чанартай төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлаагүй байна.

2.4 Улсын төсөвт тусгуулах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгцээ шаардлагын дагуу эрэмбэлсэн жагсаалтыг аймгийн Засаг даргын 2021 оны 7 дугаар сарын 26- ны өдрийн 1-2043 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

2.5 Тус эрэмбэлсэн жагсаалтад орсон “Алслагдсан сумдын дуудлагын түргэн тусламжийн зориулалтаар тоноглогдсон автомашин /Өмнөговь, Даланзадгад, Гурвантэс, Ханбогд, Ноён, Цогтцэций сум/” нэг төсөл, арга хэмжээ батлагдсан байна.

2.6 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх бусад төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, газрын зөвшөөрөл, хэрэгцээ шаардлагыг тооцоогүй, эрэмбэлсэн судалгаа байхгүй байна.

2.7 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хөрөнгө оруулалттай холбоотой заалтууд 2023 оны төсвийн жилээс эхлэн хэрэгжихээр заасан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжсэнээр төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаанд санхүүжилтийг бодитой төлөвлөх, өртгийг нэмэгдүүлэхгүй байх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон төсөл, арга хэмжээг төлөвлөж төсвийн үр ашгийг нэмэх боломжтой байна.

БҮЛЭГ 2. ЗАХИАЛАГЧ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИХ ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Б.1 Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжихээр эрх шилжсэн нийт 6 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны алба зохион байгуулсан байна.

Хүснэгт 5 2022 онд хийсэн ХАА зарласан төсөл, арга хэмжээ

/сая.төг/

№	Хуулийн	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Эрх шилжүүлсэн шийдвэр	Үнэлгэний	Тендер		Тендер шалга	ХАА-нд мөр
							Тендер хүлээж		

	дугаар			Тийм, үгүй	Огноо	Дугаар	хороо байгуулсан огноо	Зарласан огноо	авах эцсийн хугацаа	руулалт зохион байгуулсан удаа	дөдсөн жур ам
1	XII.1.117	БХБ С	Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга /Өмнөговь, Хүрмэн, Цогт-Овоо, Гурвантэс сум/ Цогт-Овоо	тийм	2021.12.01	359 дүгээр тогтоол	2022.02.18	2022.02.23	2023.03.25	1	НТШ
2	XII.1.117	БХБ С	Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга /Өмнөговь, Хүрмэн, Цогт-Овоо, Гурвантэс сум/ Гурвантэс	тийм	2021.12.01	359 дүгээр тогтоол	2022.02.18	2022.02.24	2023.03.25	1	НТШ
3	XII.1.117	БХБ С	Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга /Өмнөговь, Хүрмэн, Цогт-Овоо, Гурвантэс сум/ Хүрмэн	тийм	2021.12.01	359 дүгээр тогтоол	2022.02.18	2022.02.25	2023.06.14	3	НТШ
4	XIX.3.8	ЭМС	Алслагдсан сумдын дуудлагын тусламжийн зориулалтаар тоноглогдсон автомашин /Өмнөговь, Даланзадгад, Гурвантэс, Ханбогд, Ноён, Цогтцэций сум/	тийм	2022.01.18	А/30 дугаар тушаал	2022.01.27	2022.01.28	2022.03.01	1	НТШ
5	VI.1.16	БОАЖС	Өмнөговь аймгийн аялал жуулчлалын бүс, байгаль, түүх соёлын өв бүхий Хонгорын голын Дуут манханд отоглох цэг байгуулах	тийм	2022.02.14	БОАЖС айдын 2022 оны а/29 дүгээр тушаал	2022.02.28	2022.02.28	2022.03.09	1	ХА
6	VI.1.16	БОАЖС	Өмнөговь аймгийн аялал жуулчлалын бүс, байгаль, түүх соёлын өв бүхий газар /Ёлын амын Оюут-т отоглох цэг байгуулах	тийм	2022.02.14	БОАЖС айдын 2022 оны а/29 дүгээр тушаал	2022.02.28	2022.02.28	2022.03.09	2	ХА

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

1.2 Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.13-д заасны дагуу 2022 оны төсвийн тухай хууль 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсанаас хойших хугацаагаар тооцоход захиалагч хуулиар өөрт олгогдсон эрхийг 2022 оны 01 дүгээр сарын 11-ны өдөр хүртэл буюу 60 хоногийн дотор шилжүүлэхээр байна.

1.3 Дээрх журмын дагуу захиалагчаас холбогдох албан тушаалтанд эрх шилжүүлсэн хугацааг хянахад Эрүүл мэндийн сайдаас шилжүүлсэн төсөл арга хэмжээ 1, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаас 2 төсөл, арга хэмжээний эрхийг 33 хоногоор тус тус хугацаа хоцроосон байна.

1.4 Эрх шилжсэн 6 төсөл, арга хэмжээнээс 5 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг тайлант онд хэрэгжих боломжтой байдлаар зохион байгуулсан байна.

1.5 Харин “Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга /Өмнөговь, Хүрмэн, Цогт-Овоо, Гурвантэс сум/ Хүрмэн”-ны 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 3 удаа зохион байгуулснаас шалтгаалан гэрээ байгуулж гүйцэтгэх ажил оройтсон байна..

1.6 Дээрх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороод нь тендерийн баримт бичгийг ТБОНӨХБАҮХАТХ болон Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу боловсруулж батлуулсан байна.

1.7 Худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй, цахим хэлбэрээр зохион байгуулж, 4 төсөл арга хэмжээг НТШ, 2 төсөл, арга хэмжээг ХА-аар зарласан байна. Тайлант онд худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол гараагүй байна.

Б.2 Гүйцэтгэгчтэй байгуулсан зарим гэрээний хугацаа дууссан байна.

2.1. Улсын төсвөөс эрх шилжсэн шинээр хэрэгжих -6, өмнөх оноос шилжсэн- 7, нийт 13 ТАХ байгаагаас 2022 онд хэрэгжиж дууссан 10, он дамжин хэрэгжих 3 төсөл, арга хэмжээ байна.

2.2. Хэрэгжиж дууссан 10 төсөл, арга хэмжээний 9 нь барилга байгууламж, 1 нь авто машин байна.

2.3. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн “Цэцэрлэгийн барилга худалдан авах, 200 ор /Өмнөговь, Цогтцэций сум/” 2020 онд эхэлсэн ажил одоог хүртэл үйл ажиллагаагаа эхлээгүй байна. Өмнөх аудитаар дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Цогтцэций сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга худалдан авах ажил гэрээнд заасан хугацаанаас 102 хоногоор хоцроож хүлээлгэн өгсөн,
- Цэцэрлэгийн зориулалтаар худалдан авсан барилга нь анх үйлчилгээний зориулалтаар хийгдсэн тул MNS6558:2015, ISO8124 цуврал стандартыг хангасан гадаа тоглоомын талбай, ногоон байгууламж, гадна зориулалтын автомашины зогсоол байхгүй, цэвэр бохирын шугамд холбогдоогүй, хөдөлгөөнт төв замд ойрхон, захиалагчийн ажлын даалгавар, ерөнхий шаардлагыг хангаагүй,
- Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг үндэслээгүй ажил хийсэн нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулах, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулсан байна.

2.4. Эрх шилжиж шинээр хийсэн 6 төсөл арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээ тухайн онд гэрээний хугацаандаа дуусгаж хүлээн авсан байна. Үүнд:

- Цогт-Овоо суманд 147.3 сая төгрөгийн өртөгтэй нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга батлагдсан зураг төсвийн дагуу хугацаандаа хийгдсэн байна.

Зураг 1. Цогт-Овоо сумын “Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга”



- Өмнөговь аймгийн аялал жуулчлалын бүс, байгаль, түүх соёлын өв бүхий Хонгорын голын Дуут манханд отоглох цэг байгуулах 98.6 сая төгрөгийн байгууламжийг зураг төсвийн дагуу хугацаандаа хийсэн байна.

Зураг 2 Дуут манханд хийсэн отоглох цэг



- Мөн Ёлын амын Оюутад отоглох цэг байгуулах 99.1 сая төгрөгийн байгууламжийг зураг төсвийн дагуу хугацаандаа хийсэн байна.

Зураг 3 Ёлын аманд хийсэн отоглох цэг



- Гурвантэс суманд байгуулах нийтийн ахуйн үйлчилгээний төвийн 144.9 сая төгрөгийн ажлын гэрээ 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөр дууссан боловч барилгын материалын үнэ болон хил хааснаас шалтгаалан дуусаагүй, гэрээг сунгаагүй байна.

Зураг 4 Гурвантэс сумын Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга



- Хүрмэн суманд байгуулах нийтийн ахуйн үйлчилгээний төвийн 148.5 сая төгрөгийн ажлын гэрээ 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр дууссан боловч барилгын материалын үнэ болон хил хааснаас шалтгаалан дуусаагүй, гэрээг мөн сунгаагүй байна

Зураг 5 Хүрмэн сумын Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилга



- Цогт-Овоо сумын 320 хүүхдийн суудалтай сургуулийн барилгын ажил 2019 оноос эхэлж одоогоор ажлын гүйцэтгэл 94%-тай үргэлжилж байна. Сунгалт хийсэн гэрээний хугацаа 2022 онд дууссан байна.

Зураг 6 Цогт-Овоо сумын сургуулийн барилга /одоогийн/



- Алслагдсан сумдын дуудлагын түргэн тусламжийн зориулалтаар тоноглогдсон нэг бүр нь 172.0 сая төгрөгийн өртөг бүхий автомашиныг 5 суманд нийлүүлсэн байна.

Зураг 7 Нийлүүлсэн автомашин



2.5 Аймгийн хэмжээнд 2019 оноос хойш хийгдэж байгаа Цогтцэций сумын 960 хүүхдийн сургуулийн барилгын ажил гүйцэтгэгч компаниас шалтгаалан 2022 онд ажил хийгдээгүй орхигдсон байна.

Зураг 8 Цогтцэций сумын сургуулийн барилга



Б.3 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

3.1. Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д зааснаар төсөл, арга хэмжээ бүрээр захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгохоор заасан байдаг.

3.2. Шинээр эрх шилжсэн болон он дамжсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг дээрх журмын дагуу захиалагчийн хянаж баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн олгосон байна.

3.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд эрх шилжиж хийгдсэн төсөл, арга хэмжээнүүдэд нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулаагүй байна.

Б.4 Төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

4.1. Захиалагч, зохиогчийн зүгээс үе шатны ажлыг тухай бүр хянаж илэрсэн зөрчил, өгсөн зөвлөмжийн талаар талбайн журналд тэмдэглэн хянаж, ажлын гүйцэтгэлийг актаар баталгаажуулсан байна.

4.2. Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт үр дүнд дотоод хяналт шалгалт хийгээгүй байна.

4.3. Цаашид Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн төсөл, арга хэмжээг тухайн онд хяналт шалгалтыг зохион байгуулах шаардлагатай байна.

Б.5 Төсөл, арга хэмжээний бүртгэл хөтлөлтийг хууль журмын дагуу сайжруулах шаардлагатай байна.

5.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хийж дууссан төсөл, арга хэмжээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэргүйгээр орон нутагт ашиглагч байгууллагууд бүртгэсэн байна. Үүнд:

- Баян-Овоо сумын Төрийн албан хаагчдын орон сууцны барилгыг аймгийн Орон сууц корпораци,
- Цогт-Овоо сумын Нийтийн ахуй үйлчилгээний төвийн барилгыг сумын ЗДТГ,
- Хог хаягдал боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг Даланзадгад сумын Захирагчийн ажлын алба хөрөнгийн бүртгэлдээ тусгасан байна.

5.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн ажлуудыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

- Өмнөговь аймгийн аялал жуулчлалын бүс, байгаль, түүх соёлын өв бүхий Хонгорын голын Дуут манханд отоглох цэг байгуулах 98.6 сая төгрөг,
- Өмнөговь аймгийн аялал жуулчлалын бүс, байгаль, түүх соёлын өв бүхий газар /Ёлын амын Оюут/-т отоглох цэг байгуулах 99.1 сая төгрөг.

5.3. Бүртгэлд тусгаагүй барилга, байгууламжуудыг бүртгэлжүүлэх албан шаардлагыг Орон нутгийн өмчийн газарт хүргүүллээ.

5.4 Улсын төсвийн хөрөнгөөр Цогтцэций суманд хийгдсэн 200 ортой цэцэрлэгийн барилга худалдан авах ажил 2020 онд эхэлсэн боловч одоог хүртэл үйл ажиллагаагаа эхлээгүй, зориулалтын дагуу ашиглахгүй байгаа нь төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулж байна.

БҮЛЭГ 3. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТНЫ АЖЛЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

В.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд аудитын дүгнэлтийг тусгах шаардлагатай байна.

1.1 Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/3 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2/4 дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус баталсан байна.

1.2 Аймгийн ИТХ-ын 2021 оны 12-р сарын 02-ний өдрийн 4/7 дугаар тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хийх 155 төсөл, арга хэмжээнд 98,984.4 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

1.3 Төсөвт тодотгол хийж 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 6/1 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх ерөнхий нэрээр 165 төсөл, арга хэмжээ, задалбал 263 төсөл арга хэмжээнд 102,695.3 сая төгрөг баталсан байна.

1.4 Сумдын ИТХ тогтоолоор 2022 онд хийх нийт 177 төсөл, арга хэмжээнд 19,657.6 сая төгрөг зарцуулахаар баталсан байна.

Хүснэгт 6 2022 оны батлагдсан төсөв, ОНТХО-ын төлөвлөгөө

/сая.төгрөг/

№	Сумд	Нийт орлого	Нийт зарлага	ОНТХО-ын	
				ТАХ-ий тоо	дүн
1	Баяндалай	1,599.7	1,599.7	4	108.0
2	Баян-Овоо	2,636.2	2,636.2	0	-
3	Булган	1,563.6	1,563.6	0	-
4	Гурвантэс	10,433.1	10,433.1	18	1,973.9
5	Даланзадгад	19,440.8	19,440.8	38	4,123.6
6	Мандал-Овоо	1,152.8	1,152.8	0	-
7	Манлай	3,122.4	3,122.4	10	250.0
8	Номгон	1,838.93	1,838.93	0	-
9	Ноён	3,452.2	3,452.20	0	-
10	Сэврэй	1,745.3	1,745.3	4	96.9
11	Ханбогд	61,233.4	61,233.4	63	9,411.8
12	Ханхонгор	2,098.8	2,098.7	12	306.6
13	Хүрмэн	1,461.7	1,461.7	0	-
14	Цогт-Овоо	1,453.8	1,453.8	0	-
15	Цогтцэций	27,836.3	27,836.3	27	3,386.8
16	Аймаг	478,395.2	478,395.2	263	102,695.3
Нийт		619,464.2	619,464.2	439	122,352.9

Эх сурвалж: ИТХ-ын тогтоолууд

1.5 Аймаг, сумдын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ Монгол Улсын урт хугацааны зорилтыг хангахад чиглэсэн байна.

1.6 Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 6 бүлэг, 28 зорилт, 211 арга хэмжээг багтаасан байна.

1.7 Үүнд “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого 16, Итгэл-эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлого 36, Ирээдүй-Боловсрол, инновацын хөгжлийн бодлого 32, Хөгжил- эдийн засаг, нутгийн үйлдвэрлэлийн бодлого 69, Шударга-хүний эрх, эрх чөлөө, засаглалын бодлого 31, Байгаль орчин, хариуцлагатай уул уурхай, ус, бэлчээрийг хамгаалах бодлогын хүрээнд 26 заалттай төлөвлөсөн байдаг.

1.8 Гэвч орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний зардлын шинж чанартай болон зарим барилга, байгууламж бүхий нийт 1,333.6 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээ дээрх баримт бичигтэй нийцээгүй байна. Үүнд:

- Баян-Овоо суманд цэнгэлдэх хүрээлэн байгуулах ажил 579.0 сая төгрөг,
- Баяндалай сумын угтах үдэх хаалгыг шинээр барих 59.9 сая төгрөг,
- Өмнөговь аймагт үржүүлэгдэж байгаа мах, сүүний чиглэлийн үхэрт үзлэг ангилал, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах 2.8 сая төгрөг,

- Өмнөговь аймагт үржүүлэгдэж байгаа батлагдсан үүлдэр, омгийн мал сүрэгт үзлэг ангилалтыг зохион байгуулах 17.3 сая төгрөг,
- Ханхонгор сумын Хондот багийн төвийн барилгыг шинээр барих ажил 207.6 сая төгрөг,
- Булган сумын Дэн багийн төвийн барилгыг барих 227.0 сая төгрөг,
- Даланзадгад сумын хүн амын 2022 оны хавар, зуны улирлын махны хэрэгцээг хангах ажлын үлдэгдэл 40.0 сая төгрөг,
- Даланзадгад сумын хүн амын 2023 оны хавар, зуны улирлын махны хэрэгцээг хангах, махны хомсдол, үнийн хөөргөдөл үүсгэхгүй байх, үнийг тогтворжуулах зорилгоор махны нөөц бүрдүүлэх /Хан сайхан говь ХХК/ 100.0 сая төгрөг
- Даланзадгад сумын хүн амын 2023 оны хавар, зуны улирлын махны хэрэгцээг хангах, махны хомсдол, үнийн хөөргөдөл үүсгэхгүй байх, үнийг тогтворжуулах зорилгоор махны нөөц бүрдүүлэх /Өнөд өвлөх трейд ХХК/ 100.0 сая төгрөг.

1.9 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хийхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээг ангилбал дараах байдалтай байна.

Хүснэгт 7 Төсөл, арга хэмжээний ангилал

ТЕЗ-ын нэр	Ангилал	2022 оны төлөвлөлт		2022 оны санхүүжилт			Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигтэй	
		ТАХ-ний тоо	Дундаж хувь	Төсөв (сая төгрөг)	Гүйцэтгэл (Сая төгрөг)	Хувь	Нийцсэн ТАХ-ны тоо	Нийцээгүй ТАХ-ны тоо
Өмнөговь	Барилга байгууламж	109	24.8	83,369.8	72,976.1	87.5	105	4
	Их засвар	80	18.2	14,706.4	10,913.6	74.2	80	0
	Тоног төхөөрөмж	160	36.4	19,145.1	12,979.4	67.8	153	0
	ТЭЗҮ	47	10.7	3,157.0	1,491.6	47.2	46	0
	Бусад	43	9.8	1,974.6	854.5	43.3	46	5
Дүн		439	100	122,352.9	99,215.2	81.1	430	9

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

1.10 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2022 онд 109 барилга байгууламжид 83,369.8 сая төгрөг, 80 их засварт 14,706.4 сая төгрөг, хамгийн олон буюу 160 тоног төхөөрөмжид 19,145.1 сая төгрөг, хамгийн бага буюу 47 техник, эдийн засгийн үндэслэлд 3,157.0 сая төгрөгийг тус тус баталсан байна.

1.11 Дээрх ангилалд багтахгүй зардлын шинж чанартай 43 төсөл, арга хэмжээд 1,974.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

1.12 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-ын тогтоолын хавсралтаар төсөл, арга хэмжээний мэдээлэл дутуу баталдаг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6¹ дахь заалттай нийцэхгүй байна.

1.13 Аймаг, сумдын ИТХ орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээний Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасан хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжилтийн эх үүсвэрийн мэдээллийг дутуу баталсан байна.

¹ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн

1.14 Мөн Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24²-д заасантай нийцэхгүй орон нутгийн өмчлөлд хамаарахгүй, улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авахад нийт 42 төсөл, арга хэмжээнд 6,808.5 сая төгрөг баталсан зөрчил илэрсэн. (Дэлгэрэнгүйг хавсралт №1)

1.15 Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-ын заалттай нийцэхгүй орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар зардлын шинж чанартай 1,771.8 сая төгрөгийн 38 төсөл, арга хэмжээг баталсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт №2)

1.16 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4³ -т заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагыг хангаагүй төсөл арга хэмжээ батлагдсанаас хойш боловсруулдаг нийтлэг зөрчил гарсаар байна. (Дэлгэрэнгүйг нэгдсэн судалгаа)

1.17 Дээрх зөрчлүүд жил бүр давтагдан гарч байгаа нь төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг алдагдуулж, төсвийн төлөвлөлтийн зарчим хангагдахгүй байгааг харуулж байна.

1.18 Цаашид төсөв боловсруулж батлахдаа Төрийн аудитын байгууллагаас төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх зардал бууруулах саналыг авч байх шаардлагатай байна. Дээрх зөрчлүүдийн талаар жил бүр Төрийн аудитын байгууллагаас өгсөн саналд дурдагдсан байна.

В.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд илэрсэн зөрчлүүд үр дүнг бууруулж байна.

2.1 Өмнөговь аймгийн хэмжээнд 2022 онд хэрэгжүүлэхээр баталсан 122,352.9 сая төгрөгөөр санхүүжүүлэх 439 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны алба, сумдын Засаг дарга нарт олгосон байна.

2.2 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжихээр баталсан төсөл, арга хэмжээний тендерийг зохион байгуулж гүйцэтгэгчийг шалгаруулахдаа 45,5 хувьд нээлттэй тендер шалгаруулалт, 17,3 хувьд харьцуулалтын арга, 6 хувьд ЗҮГСШЖ, 31,2 хувьд шууд гэрээ байгуулах аргыг ашигласан байна.

Хүснэгт 8 Төсөл, арга хэмжээний ангилал

ТЕЗ-ын нэр	Ангилал	2022 оны гүйцэтгэл		2022 оны санхүүжилт		ХАА-нд мөрдөгдсөн журам			
		ТАХ-ний тоо	Дундаж хувь	Гэрээний дүн (сая төгрөг)	Олгосон Гүйцэтгэл (Сая төгрөг)	НТШ	ХА	ЗҮГС Ж	ШГ
Өмнөговь	Барилга байгууламж	93	24.7	103,741.2	72,976.1	73	11	0	9
	Их засвар	64	17.0	11,731.4	10,913.6	35	15	0	14
	Тоног төхөөрөмж	143	38.0	15,572.8	12,979.4	60	35	0	48
	ТЭЗҮ	36	9.6	1,942.4	1,491.6	1	0	21	14
	Бусад	40	10.6	1,053.4	854.5	2	4	2	32
Дүн		376	100.0	134,041.2	99,215.2	171	65	23	117

Эх сурвалж: Нэгдсэн судалгаа

² "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

³ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

2.3 Тайлант онд орон нутгийн төсвөөс 376 төсөл арга хэмжээнд 134,041.2 сая төгрөгийн гэрээ байгуулж 2022 онд 99,215.2 сая төгрөг буюу 74 хувийг гүйцэтгэгч компаниудад олгосон байна.

2.4 Зарим төсөл, арга хэмжээ хил хаагдсан, үнийн өсөлтөөс шалтгаалан огт хэрэгжээгүй байна.

2.5 ХАА-г цахим хэлбэрээр явуулдаг болсноор ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т заасан хавтаст хэргийн бүрдэл хангахгүй архивын нэгжийг дутуу бүрдүүлсэн зөрчил давтагдсаар байна.

2.6 Аймгийн ХАА-ны үнэлгээний хороонд нийт 42 иргэний төлөөлөл орж ажилласны 23 иргэн нь 10 болон түүнээс дээш давтамжтайгаар үнэлгээний хороонд томилогдсон байна.

2.7 Энэ нь "ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.2⁴ заасантай нийцэхгүй, үнэлгээний хороог байнгын шинжтэй болгох эрсдэлийг дагуулж байна.

Хүснэгт 9 Үнэлгээний хороон ажилласан иргэдийн судалгаа

№	Үнэлгээний хороонд томилогдсон иргэдийн нэрс	Үнэлгээний хороонд ажилласан тоо
1	Г.Цэнгэлмаа	13
2	Г.Далай	16
3	Н.Адъяасүрэн	13
4	М.Соёл-Эрдэнэ	15
5	М.Лхагвасүрэн	11
6	Д.Мөнхсайхан	22
7	С.Төгсбаатар	13
8	Ч.Ариунзаяа	10
9	Б.Баяржавхлан	14
10	А.Наранцэцэг	15
11	Т.Нямсамбуу	12
12	Б.Цэвэгмэд	10
13	А.Буд-Очир	10
14	С.Отгончимэг	13
15	Б.Энхтүвшин	10
16	Б.Мөнхтуяа	13
17	Э.Энхбаяр	19
18	Г.Бямбасүрэн	16
19	Б.Чинбат	12
20	Г.Золзаяа	13
21	Б.Төмөрбаатар	10
22	Б.Цагаанцэнд	16
23	Б.Энэбиш	12

Эх сурвалж: ХАА-ны тайлан

2.8 Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороод нь тендерийн баримт бичгийг ТБОНӨХБАҮХАТХ болон Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу боловсруулж батлуулсан байна.

2.9 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, ашиглалын байдалд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

⁴ Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх ...

- Даланзадгад сумын 4-р багийн өрхийн эмнэлгийн 2-р давхрын үзлэгийн өрөө шаардлага хангахгүй зохион байгуулалттай, угаалтуур шаардлагатай 4 өрөөнд угаалтуур суурилуулагдаагүй талаар ашиглагч байгууллагын гомдол, санал гарсан байна.


Эдгээр нь зураг төсөвт тусгагдаагүй байгаа нь уг барилгын зураг төсөл нь ашиглалтын хэрэгцээ шаардлагад нийцэхгүй,

Зураг 9 Өрөөний зохион байгуулалт



- Даланзадгад сумын 23-р цэцэрлэгийн их засварын ажил улсын комиссын өгсөн үүрэг даалгаврын биелэлт дутуу,
- Цогтцэций сумын 1-р сургуульд байгалийн шинжлэх ухааны лаборатори байгуулах ажлын хүрээнд нийлүүлэгдсэн 4 ширхэг зурагт техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтэд хүрэхгүй,
- Цогтцэций сумын хөрөнгө оруулалтаар хийсэн Ногоон байгууламж, нийтийн эзэмшлийн талбайн усалгааны автомашины конс ажиллахгүй, бүх дугуй элэгдсэн, өнгө үзэмж муу, арьс зэвэрч цоорсон,

Зураг 10 Усалгааны автомашин



- Цогтцэций сумын 1 дүгээр сургуулийн барилгыг засварлах 1,074.4 сая төгрөгийн өртөгтэй ажил батлагдсан ч гүйцэтгэлээр сургуулийн өргөтгөлд цайны газрын барилга барьсан байна. Мөн улсын комисс ажиллаагүй байхад үйл ажиллагаа эхэлсэн,

Зураг 11 Сургуулийн цайны газар



- Ханбогд сумын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Үлэмжийн чанар соёлын төвд тоног төхөөрөмж авах ажилд нийлүүлэгдсэн 2 ширхэг зөөврийн компьютерын хүчин чадал нь техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтэд хүрэхгүй,
- Ханбогд сумын 1-р сургуульд компьютер тоног төхөөрөмж авах ажилд нийлүүлэгдсэн 2 ширхэг 86 инчийн ухаалаг дэлгэцийн хүчин чадал нь техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтэд хүрэхгүй,
- Сумын төвийн 2.8 км авто замын үргэлжлэл 1.5 км үргэлжлэх 1,617.0 сая төгрөгийн ажлыг 2022.04.15-нд зарласан ба тендер шалгаруулалтад сангийн яамнаас өгсөн гомдол хянасан тухай албан бичгийн шийдвэрийг хэрэгжүүлээгүй,
- Манлай сумын Эрүүл мэндийн төвд нийлүүлсэн зөөврийн рентген аппарат нь угсрагдаж суурилуудагдаагүй ашиглалтгүй,
- Мөн биохимийн автомат анализаторын дагалдах урвалж шингэн нь тус аппаратад тохирохгүй ашиглагдахгүй шингэн нийлүүлэгдсэн,

Зураг 12 Ашиглахгүй байгаа хөрөнгө



- Манлай сумын Сургуулийн архивын өрөө болон насан туршийн боловсролын өрөөг тохижуулж үдийн цайны тоног төхөөрөмж авах" ажлын хүрээнд нийлүүлсэн зарим тоног төхөөрөмж техникийн тодорхойлолтод заагдсан хүчин чадалд хүрэхгүй, Нийлүүлсэн архивын нягтруулсан шүүгээ нь угсрагдаагүй, ашиглагдаагүй байна. Мөн ашиглагч байгууллагын боловсруулсан техникийн тодорхойлолт шаардлага хангахгүй,

Зураг 13 Ашиглахгүй байгаа хөрөнгө



- Хүрмэн сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын спорт заал халаалтгүй, 10 ширхэг паар цоорч ус алдсан, ханын дээд хэсгээр битүүмжлэл муу хийгдсэн сийрэлттэй, сагсны шийтийн бэхэлгээ дутуу хөдөлгөөнтэй байгаа нь заалны хэвийн үйл ажиллагааг хангахгүй,
Зураг 14 Хүрмэн сумын сургууль



- Хүрмэн сумын уурын зуухны барилга барих ажлын гүйцэтгэл 50%-д хүрээгүй байхад санхүүжилтийг 56%-ыг олгосон,
Зураг 15 Уурын зуухны барилга



- Гурвантэс сумын сургуульд нийлүүлэгдсэн зөөврийн компьютерт 8 ширхэг хулгана дутуу, хэншүү сорогч гэр ахуйн хэрэгцээний зориулалтай, 1,2x2,4м хэмжээтэй 4ш шохой болон маркетаар бичих зориулалттай 4ш самбар, 2ш волейболын бөмбөг дутуу,
- Гурвантэс сумын сургуулийн спорт заалны засварын ажилд 14 ширхэг урт сандал, 25 ширхэг сандал суурилуулах ажил дутуу хийгдсэн,

- Гурвантэс сумын цаг уурын барилгын бүх цонх цантсан, таазанд өнгөр тогтож хөгцрөх нөхцөл байдал үүссэн,
- Ноён суманд хийсэн алслагдсан сум, багийн нутагт үүрэн холбооны сүлжээний тархалтыг нэмэгдүүлэх 200.0 сая төгрөгийн ажлын цамхгийн хэлбэр болон дахин дамжуулах байрны хэмжээ нь ажлын даалгавартай нийцэхгүй байна.

2.10 Дээрх зөрчлүүдэд дахин давтахгүй байх, зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлээ.

2.11 Шинээр болон он дамжсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг журмын дагуу захиалагчийн хянаж баталгаажуулсан ажлын гүйцэтгэлийг үндэслэн олгосон байна.

2.12 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг ГХБХБГ, Хөгжил, хөрөнгө оруулалтын газар, сумдын ЗДТГ-ууд хэрэгжүүлсэн байна.


2.13 Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт болох Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2016-2021 онуудад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, гүйцэтгэлийн байдалд хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж өгөөгүй байна.

2.14 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх ажлын тоо, санхүүжилт жил бүр өсөж байгаа тул захиалагчийн хяналтыг сайжруулж мэргэжилтнүүдийн чадвар, хүний нөөцөд анхаарах шаардлагатай байна.

2.15 Хөгжимт жүжгийн театрын барилгын ажлыг 2022 оны аудитаар хурлын заал, дууш, ариун цэврийн өрөөний ажил дуусаагүй, шатны хашлага хийгээгүй, тайзны дээрээс болон шилэн дээвэр, цонхоор цасны ус нэвтэрч гоожсон, галын крант ажиллахгүй, аваарын дизель генераторын холболт, хашаа хийгээгүй, үзвэрийн заалны тааз эвдэрсэн зэрэг нийт 65 зөрчилд аймгийн Засаг даргад зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлсэн.

2.16 Дээрх албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдөр Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар 35 зөрчлийг арилгасан талаарх албан бичиг ирүүлсэн байна.

Зураг 16 Хөгжимт жүжгийн театр





2.17 Аудитын мөрөөр хяналт хийхэд Хөгжимт жүжгийн театрын барилгын ажлын зөрчил арилаагүй байгаа тул мэргэжлийн шинжээч ажиллуулахаар төлөвлөөд байна.

2.18 Аудитын явцад Цогт-Овоо сумын төвийн дэд бүтцийг шийдвэрлэж байгуулах шугам сүлжээний угсралтын 102.0 сая төгрөгийн хөрөнгө, Даланзадгад сумын 4 дүгээр багийн өрхийн эмнэлгийн 1,273.7 сая төгрөгийн барилгыг үндсэн хөрөнгөд тусгаагүй зөрчлийг арилгуулсан.

2.19 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр эрүүл мэндийн салбарыг дэмжиж анхны бие даасан өрхийн эмнэлгийн барилгыг 1,273.8 сая төгрөгөөр барьж ашиглалтад хүлээн авсан байна. Бие даасан барилгатай болсноор эмч, ажилчдын ажиллах нөхцөл сайжирсан, үйлчлүүлэгчдийг тохилог орчинд хүлээн авч эмчилгээ, оношилгоо хийх болсон сайн төсөл, арга хэмжээ болсон байна.

Зураг 17 Өрхийн эмнэлэг



ДҮГНЭЛТ Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр орон нутагт хийсэн төсөл, арга хэмжээ монгол улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн үндсэн зорилготой нийцэхгүй байна
- Иргэдийн хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийн дагуу эрэмбэлсэн төсөл, арга хэмжээ улсын төсөвт бүрэн тусгагдаагүй байна
- орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд төсвийн төсөлд өгсөн аудитын дүгнэлтийг тусгах шаардлагатай байна
- Өмнөговь аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хийх төсөл, арга хэмжээ жил бүр буурсаар байна.
- Гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулсан байна
- төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.
- Захиалагч гэрээний хэрэгжилтийг хангуулах ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна
- Хөрөнгө оруулалтын бүртгэл хөтлөлтийг сайжруулах шаардлагатай байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн зарим төсөл, арга хэмжээнд илэрсэн зөрчлүүд үр дүнг бууруулж байна.

ЗӨВЛӨМЖ Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймаг, Сумдын ИТХ-д

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээг батлахдаа Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасан мэдээллийг бүрэн тусгах.

Аймгийн Засаг даргад:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийх төсөл, арга хэмжээний зураг, төсөв боловсруулахдаа ашиглагч байгууллагуудын саналыг тусгаж байх.
2. Төсөл, арга хэмжээг хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг хариуцлагажуулах талаар чиглэл өгч, хяналт тавьж байх,
3. Үнэлгээний хороонд ажиллах иргэний төлөөллийг сонгохдоо ажил эрхлэлтийн байдал болон бусад нөхцөлийг харгалзан үзэх, нэг иргэний төлөөллийг олон ажилд томилохгүй байх.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/11

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэхь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ийн 18.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Г.Шижирболд)-д даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

D:\2023 Он\Бичиг Хэрэг\А Тушаал\А-11.Doc

016010019